

АНГИ: 12

ХИЧЭЭЛ: МОНГОЛ ХЭЛ

ХУВИЛБАР: №8

ХИЧЭЭЛИЙН СЭДЭВ: Нийтлэлийн утга, бүтцийн онцлог

СУРАЛЦАХУЙН ЗОРИЛТ: 12.1a. Уран нийтлэлийн бүтэц, утгын хамаарлаар нийтлэлийн онцлогийг тайлбарлах

Дараах нийтлэлийг анхааралтай уншаад, даалгаврыг гүйцэтгээрэй.

Миний эх орон – Миний тоонот

Хэдэн жилийн өмнө намар цаг Алтайд явахдаа Ховд голын Баян нуурын тавилан дээр түр саатаж билээ. Ховд голын ус хүүхдийн сэтгэл шиг тунгалагхан мэлмэрээд, намрын алтан улиас ганц хоёр навчаа харуусах мэт уснаа орхин, аян замд баахан алжаасан бид дуу шуу цөөнтэй бодол болон Алтайгаа халиаж суусан сан.

Тэртээ умард тэнгэрийн мандалд Хархираа Түргэний бадамласан цагаан оргилууд бага насны гэгээн зөгнөлд ургадаг асан үлгэрийн орныг санагдуулан, өмнөхөн талд Цамбагарав гэж бардам нэртэй их уул цаст оргилынхоо сэрүүн цагаан салхийг бидний зүг илгээн байлаа. “Чи бас азтай хүн шүү!” гэж ямар нэг далдын юм чихнээ шивнэхүйд “Би бас азтай хүн шүү” гэж дотроо давтан хэлж билээ. Тэгтэл “Энэ сайхан эх орон чинь хаанаас эхэлсэн билээ” гэж өөрөөсөө асуун Онон голын хойд бие Галт хан гэдэг хадат хөх уулын өвөрт, орхигдсон өвөлжөөний арын дэнжид байдаг тоонотоо харах шиг болсон. Эхээс төрөхөд хүйсийг минь булж дарсан тоонот хэмээх тэр нэг элгэн хүрэн чулуу юутай бүлээхэн санагддаг билээ. Тоонот гэрээ барих хүн төрлөө гэж тоонот гэсэн тохмын чинээхэн газраас эх орон минь эхэлсэн гэлтэй. Тэндээс амьдралын минь өлзийт зам эхэлж, би эх орноо таньсан.

Үзүүр шугуйн модонд

Үрээн бугын гүйдэлтэй

Үзээд хойшоо харахад

Ийм л хол Алтай даа гэсэн дуутай алсын хүдэр баян Алтайдаа би иржээ. Казакын хар нүдэн бүсгүй домбор хөгжмийн эгшгэнд уяхан биелгээ хийж, шар шувууны өд хатгасан малгайтай эрэмгий эрчүүд жороо морь уралдуулахыг үзээд, халирхаж хачирхсангүй, харин ч сэтгэл уяран Онон голын шугуйд хур шиг шаагих адуунд явдаг асан ангир шарга морио, айл аймаг, ах дүүгээ гэнэтхэн их санаж билээ. Алтайдаа миний тоонот байлаа.

“Хоёр хангайн нутаг хүрэнэтэй найгана,

Хошууны олон та нар минь санагдах л янзтай”. Аль тавин долоон оны зун Архангайн урд Тамирын хөвөөнөө сонссон энэ дуу сэтгэлд уяатай явдаг юм. Жаран долоон онд Энэтхэг Жумна мөрний хөвөөнд зогсон байтал тэр дууны үг, аялгуу сэтгэлд орж ирэхэд “Би чинь нутгаа саначихжээ. Түргэхэн л харья” гэж бодсон сон. “Хоёр хангайн нутаг хүрэнэтэй найгана” гэхээр сэтгэлд нэг юм бууна шүү дээ, та минь. Өвөрхангайн Найман нуурыг үзээгүй бол нутгийнхаа сайхныг мэдсэн гэж бүү бод гэж хэн хэллээ дээ. Тийнхүү Найман нуурыг үзье гэж бодон бодсоор бас л нэг намар, шувууны зудаар хүрээд очлоо. Ширээтийн даваан дээр гараад ирэхэд хүрэнтэн найгах хөвч уулсын дунд холбоо Найман нуур мэлтэс хийн харагдаж билээ. Тэртээ чанадад Орхон мөрний эхний уулс униартан цэнхэрлэж сэтгэл уужруулан “Энэ сайхан орондоо урт удаан насалж их юм бүтээх сэн” гэсэн сэтгэл аяндаа төрж билээ. Бага диваажин хэмээх Найман нуурыг үзээд үнэхээр нас нэмэх шиг болсон. Энэ дэлхий дээр хэчнээхэн амьд явахыгаа мэдэхгүй боловч нутаг усныхаа үзэсгэлэн гоог бишрээд нас нэмлээ гэж бодох ч жаргал шүү дээ. Хангайдаа миний тоонот байлаа. Би говьд сэтгэлтэй болсон хүн. Шаргын говиос Галавын говь хүртэл явж хүн байгаль хоёрын мөнхийн тулалдааны шаштир болсон тэрхүү гайхамшигтай бөгөөд сэтгэл

булаах далдын их увдистай сүр хүчин яруу уянга хосолсон газар нутгийнхаа бүлээн дулааныг мэдрэхүйд “Ямар их хувь заяагаар бид эзэн нь болж төрөв” гэсэн шүлэгчийн үг санагдаж билээ. Говьд олон ч удаа очлоо.

Очих бүрийд заавал нэг сонин сайхан талаасаа үзэгдэн, бодлын түмэн сэжүүр гаргаж өгнө. Говийн байгальд яруу уянга, сүр хүчин хосолсон нь хүндээ бас шингэжээ. Би говийн хүний ааш араншинг таниад амьдралд илүү их итгэсэн. Тийрэлтэт онгоцны утаан сүүл мэт хулангийн цагаан тоос, уулсыг газраас тасалсан усан бага насны яруу найраг сэрэн алдаад ер сэтгэл алжаалж, онгод унтрахын цагт эх орны газар шороо, уул уснаас урам зориг төдийгүй ухаан бодол ч ургаж болохыг мэдэрнэм билээ. Зуны цэнгэлэгхэн орой гурван сайхны хяр дээрээс говийн манант алсыг ширтэж чухам ямархан үгээр зурж болохыг олж ядан суутал “Үлэмжийн чанар”-ыг бүрэн шингээсэн ялдамхан бор бүсгүй цагаан тэмээ унаад ирж явна гэж зүүдлэх мэт болсон тэр цагаас хойш түүнийг говийн бэлгэ тэмдэг гэж бодох болсон билээ. Говьдоо миний тоонот байлаа.

Дорнодын тал минь. Монгол хүний суу залиг бадруулсан баян тансаг, хотол төгөлдөр тал минь. Гадаад их далайн давалгаа мэт үелзэнхэн тогтсон ухаа гүвээнүүдийг давж, Хэрлэн мөрний холч урсгалыг дагаж хэчнээн ч явав даа. Талдаа очиход сэтгэл найман сарын нарлаг өдөр шиг дэлгэр тэнүүн боллоо. Ганган нуурын ганган улаан бургас ганхаж байхыг үзсэн цаг амьдралын их олз мэт санагдан Тоорой бандийн домогт Шилийн богд, талын дунд асарлан цэнхэрлэхүйд монгол хүн оршин амьдарсан цагаас энэ гэрэлт дуулим тал минь хэчнээн юм үзээ бол оо гэх зэрэг олон юм бодогдсон сон. Өнгөрсөн дайны талбар монгол хөвгүүдийн цус шингэсэн Халхын голын дэнж талд алимны мод цэцэглэн хэдэн сая дүнчүүр цагаан эрвээхэй газарт буусан юм шиг эх орон эх нутгаа харийн дайснаас өмөөрөн тэмцэж амь алдагсдын гэгээн дурсгалыг тийнхүү таван сарын цагаан эрвээхэй цэцгээр мялаасан юм шиг байхыг би үзсэн. Хэрлэнгийн усаар ундаалсан халхын удамт хурдан хүлгүүдийн тоосон дундаас түмний эх цойлон гарч, унасан хүүхдүүдийн цовоолог дуун хангинахад учиргүй уяхандаа биш сэтгэл жигтэй догдолсондоо нулимсаа сэмхэн арчиж явснаа хүртэл тэр болгон тохиолдоогүй явдал шиг санах юм. Талдаа миний тоонот байлаа.

Алтай, хангай, говь, тал. Миний эх орон – Миний тоонот билээ.

С.Эрдэнэ